

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:


“XIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах асуудлыг хэлэлцээд дараах арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт даалгав:

1. Зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү бохирдуулагч бодис ялгаруулж байгаа нийтийн тээврийн автобус, дизель түлш хэрэглэдэг ачааны автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, автотээврийн хэрэгсэлд утаа шүүгч суурилуулах ажлыг нийтэд сурталчлан таниулж, иргэдийн саналыг авсны үндсэн дээр зохион байгуулах;

2. Дизель түлш хэрэглэдэг автобус импортоор оруулах асуудлыг үе шаттайгаар хориглох арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хяналт тавих;

3. Автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг судалж танилцуулах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

